

түмний уламжлалт дэвшилтэт өв уламжлалыг амьдралын бүхий л салбарт хадгалах, үндэсний уламжлалт соёлыг орчин үеийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн дэвшлийн элементтэй зөв хослуулах бодлого баримталж байна.

Тус оронд үйлдвэржих, хотжих, суурьших, мөн улс хоорондын хамтын ажиллагаа хэдий эрчимтэй хөгжиж байгаа боловч монголчуудын үндэснийхээ өвөрмөц шинж чанар, соёлоо гээж байна гэж үзэх үндэсгүй.

ШИНЖЛЭХ УХААН,  
СОЁЛ

**ШАГЖИЙН «ЧАНДМАНИЙН  
ЭРХ»**

А. ЛУВСАНДЭНДЭВ  
ШУА-ийн сурвалжлагч гишүүн

1929 онд тэр үеийн Шинжлэх ухааны хүрээлэнгийн ажилтан, толь бичгийн ухааны гарамгай эрдэмтэн Шагж гэлэн «Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманий эрх» гэсэн гарчигтай монгол хэлний тайлбар толийг зохиож дуурсгасан нь эдүүгээ Улаанбаатар хотын Улсын нийтийн номын сангийн бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байна. Уул толийг орос цаасан дээр бичгийн машинаар маш нямбай цохижээ. Цаасны хэмжээ 23,5 x 20 см, бүгд 4 дэвтэр, оршил 2 тал хуудас, дугааргүй, жинхэнэ эх нь 1628 тал хуудас, хар бэхээр бийрээр монгол тоогоор хуудсыг дугаарласан, тал хуудас нь дугааргүй байна. Шар өнгийн даавуу хавтастай, хавтасны нүүр дээр «Монгол үгний тайлбар бичиг. Нэгдүгээр дэвтэр» гэх мэтчилэн гарчиглажээ. Шифр 494. 21. III 156, I, II, III, IV, дугаар 15760, 15761, 15762, 15763.

«Эрэхүйеэ хялбар болгон зохиосон» гэсэн гарчигтаа зохиогч бүтээлийнхээ зорилго, зарчмыг товчхон боловч тодорхой тунхагласан байна. Бидний гар дээр байгаа хэрэглэгдэхүүн мэдээ сэлтээс үзэхэд урьдын эрдэмтдийн зохиосон монгол хэлний тайлбар толиуд цөм зүйл хуваасан толь байлаа. Зүйл хуваасан толиноос хэрэгтэй үгээ олж үзэх гэдэг тийм хялбар биш, үлэмжхэн цаг гарзаддаг нь хэн бүхний мэдээжийн хэрэг билээ. Шагж гэлэн шал өөр зарчим дээр үндэслэсэн өөрөөр хэлбэл уйгаржин монгол үсгийн дэс дараа дээр үндэслэсэн толь зохиож, өмнө дурдсан дутагдлаас уншигч олон түмнийг ангижруулахаар шийджээ. Түүний бичсэн оршилд «Энэ бичгийг зохиосны санаа зорилгыг товчилбоос, ард олныг хэл бичигтээ амархнаар боловсорч, элдвээр бичих сонжигдох элэгдэхээс гэтлэн, үг өгүүллээр гачигдан мухардахуйн зовлонгоос даруй ангижиртугай хэмээсэн нь буюу» гэж бичсэн байна.<sup>1</sup>

Иш татсан зүйлээс үзвэл, зохиогчийн зорилго тайлбар толийг ашиглахад хялбар болгох төдийгөөр хязгаарлагдсангүй, уншигч олныг монгол утга зохиолын хэлний үгсийн сангийн баялгийг зөв эзэмшүүлэх, зөв бичүүлж сургахыг нэгэн адил эрмэлзжээ. Мөнхүү оршилд Шагж гэлэн «манай улсын эрт цагт орчуулсан, зохиосон судар шаштирыг шинжилбээс мөнхүү дүрэм хэмжээ агсан нь илэрхий атал, хожмын үед бичгийг ёсчлон сурахуйд маш бэрхтэй болж их төлөв нь балрагдан, нялхасын

бичиг мэт зүйл зүйлээр бичих ба, нийтэд эс алдаршсан ийхэр шийхэр үгсийг хоорондын бичигт хэрэглэх болсон нь гагцхүү эрж олохуйд хялбар болгон зохиосон тайлбар толь үгүйгээс болжээ»<sup>2</sup> гэж бичсэн нь үсгийн дүрмийг сахиулахаас гадна үсгийн сангийн нийгэмд мөрдүүлэх хэв журмыг тогтоож, тайлбар толь бичгийг Монгол хэлний түгээмэл сурах бичиг болгох гэж оролдож байсан урьдын эрдэмтдийн уламжлалыг үргэлжлүүлсэн нь буюу<sup>3</sup>.

Шагж гэлэн «Чандманий эрх» хэмээх энэхүү тайлбар тольдоо хорьдугаар зууны анхдугаар мөчлөгийн монгол утга зохиолын хэлний үсгийн сангийн идэвхтэй хэсгийг аль болохоор бүрэн багтаахыг эрмэлзжээ. Урьдын эрдэмтдийн зохиосон толь бичгүүдэд уламжлагдан ирсэн хуучирсан үг хэллэг, нэр томъёог таягдан хаясан нь манай толь бичиг судлалд оруулсан Шагж гэлэнгийн нэг хувь нэмэр даруй мөн. Шагж гэлэн ингэж Монголын толь судлалд үлэмжхэн шинэ зүйлийг оруулсан боловч, монгол хэлний шинэ тайлбар толь зохиоходоо өнгөрсөн үеийн эрдэмтдийн бүтээлүүдийг гол тулгуур болгон ашигласан байна.

Хаяан-u bičigsen manju mongyol ügengü toli bičig<sup>4</sup>, Хаяан-ну bičigsen manju mongyol ügen-nü toli bičig<sup>5</sup>, Хаяан-u bičigsen dörben jüil-ün üsüg xabsuruysan manjü ügen-ü toli bičig, Хаяан-u bičigsen manju mongyol, kitad yurban juil-ün üsüg xabsuruysan čayan toloyani-yin des daray-a-bar ayalyu-yi hadaysan manju ügen-ü tali bičig зэрэг гол гол толь бичгийг үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигласан тухай оршилдоо бичсэн байх бөгөөд энэ нь толийн эхийг судлан үзэхэд нотлогдож байна.

Шагж гэлэн толь бичиг судлалын хуучин сургуультаан эрдэмтдийн нэгийн хувьд урьдын эрдэмтдийн бүтээлийг туйлаас хүндэтгэн, онцын шалтгаангүйгээр тэдний бүтээлд ямарваа нэгэн өөрчлөлт оруулахгүй, хэвээр хадгалан, хойшид уламжлуулах ёстой гэж үздэг байв. Жишээ болгон «сар» гэдэг үг орсон хэдэн толгой үгийг «Чандманийн эрх» ба «Хорин нэгт тайлбар тольд» хэрхэн тайлбарласныг авч үзье.

«Чандманий эрх»<sup>6</sup>

Sar-a)) naran saran yučin edür-ün  
dotora ularin kürcü ireküi-yi +

Sar-a bay-a)) yučin edürülü  
kürkü sar-a-yi+

Sar-yeke)) yučin edür kürkü  
sar-a-yi +

Sar-a-bar)) kedü kedun sar-a  
boltal-a kemekkui-yi+

Sar-a büri)) sar-a tutum  
kemekü üge

Sar-a yin xayučid)) xorin  
xoyisi nige kedün edür-i+

Sar-a yin Sined-iyer))  
sin-e-yin nigen-eče xoyisi.  
nige kedün edür-i+

Хорин нэгэн тайлбар толь<sup>7</sup>

Car-a naran saran yučin edür-ün  
dotora ularin kürcü ireküi  
nige sar-a kememüi

Car-a bay-a yučin edür kürkü  
sar-a-yi sar-a bay-a kememüi

Car-a yeke yučin edür kürkü  
sar-a-yi sar-a yeke kememüi

Sar-a-bar kedu kedün sar-a  
boltal-a kemekü üge

Sar-a büri darui sar-a tutum  
kemekü uge

Sar-a-yin x ayučid aliba car-a  
yin xorin-ača ača

xoyisi nigen

kedün edür-i sar-a-yin xayučid  
kernemüi

Sar-a-yin Sined aliba sar-a-yin  
sin-e-yin nigen eče xoyisi

Sar-a-yin-ki)) tere sar-a  
yin kereg, ene sar-a-yin kereg-i  
rere sar-a-yin-ki, ene sar-a-yin  
ki kememüi

nigen kedün edür-i sar-a-yin  
Sined kememüi  
Sar-a-y in- ki tere sar-a-yin  
kereg, ene sar-a-yin kereg-i  
tere sar-a-yin-ki, ene sar-a  
yin-ki kememüi

Ийнхүү «сар» гэдэг үг, «сар» гэдэг үг бүрэлдэхүүнд нь орсон холбоо үгсийг «Чандманий эрх», «Хорин нэгт тайлбар толь» хоёрт хэрхэн тайлбарласныг харьцуулан үзвэл үг үсэгчлэн адил байх бөгөөд ялгаа нь гэвэл «Хорин нэгт тайлбар тольд» тайлбарын эцэст толгой үгийг давтан бичээд «хэмээмүй» гэж нэмдгийн оронд Шагж адил үгийг олон давтахгүйн тул тоонолжин тэмдэг тавьжээ. Тайлбар бүрийн төгсгөлд толгой үгийг «сар наран саран гучин өдрийн дотор улиран хүрч ирэхийг нэг сар хэмээмүй» гэх мэтчилэн давтаж, «хэмээмүй» гэж нэмж би чих нь төдий л дадлагатай бус уншигчдад зориулсан тайлбар тольд арга зүйн хувьд зөвтгөх талтай нь үзтэл илэрхий. Шагж гэлэнгийн шинэчлэл өнгөцхөн харахад өчүүхэн зүйл мэт боловч, орчин үеийн толь зохиох арга барилыг эзэмшин, улам боловсронгуй болгоход монгол хүний хийсэн анхны алхмын нэг, цаашилбал бараг тайлбар бүрээс хоёроос доошгүй үг товчилж, үлэмжхэн цаг, цаас, хөдөлмөр хэмнэсэн байна.

Урьдын эрдэмтдийн бүтээлд хэрхэн хандах асуудалтай холбогдуулан Шагж гэлэнгийн оршлоос нэг хэсгийг сийрүүлбэл «...эдгээрийн (урьдын эрдэмтдийн бүтээлийн—Л) зөрөлдсөнийг олонхийг нь баримтлан, эс ухсан зүйлүүдийг эрдэмтэн нөхдөөс лавлаж, энэ үед бага сага хэрэг болох болзошгүй зүйлүүдийг нь цөм хураан авч, тун ч эс хэрэглэгдэх мэтсийг нь огоорч, жич бас эрт эдүүгээгийн эрдэмтэн мэргэдийн зохиол бүтээлээс нэмэн оруулж, тус улсын арван зургадугаар оноос эхлэн гурван жил өдөр шөнө хэмээх үгүй өөрийн чинээгээр чармайн орол дож араахан төгсгөвэй»<sup>8</sup> гэжээ. Энэ хэдэн мөрт хуучин сургуультаан эрдэмтдийн толь бичиг зохиох зарчмыг маш товчхон боловч ойлгомжтой илтгэжээ. Үүнд: 1) урьдын эрдэмтдийн бүтээлд ижил байгаа зүйлийг яг Хэвээр нь уламжлах; 2) зөрөөтэй зүйлийг олонхийг нь баримтлан шийд вэрлэх; 3) өөрсдийн үл мэдэх зүйлийг бусдаас асууж сурвалжилж ший дэх; 4) орчин үед өчүүхэн боловч хэрэгтэй зүйлсийг хадгалан уламжлуулах; 5) эдүүгээ хэлэнд нэгэнт хэрэглэгдэхгүй болсон зүйлсийг хасах; 6) урьдын ба эдүүгээгийн ном зохиолоос хэрэгцээтэй зүйлсийг нэмж оруулах өөрөөр хэлбэл толь бичиг зохиогч юуны ч тухай санаанаасаа авч бичиж болохгүй, юм бүхний бодитой баримт дээр тулгуурлан бичих ёстой.

Санскрит цагаан толгойн үсгийн дэс дараатай төстэй уйгуржин монгол цагаан толгойн үсгийн дэс дараагаар толийн үсгийн жагсаалтыг байрлуулсан байна. Толгой үсэг бүрийн өмнө «Монгол үгний тайлбар чандманийн эрхээс а-гийн аймаг» гэх мэтчилэн гарчиг тавьсан байна. Уул толийн толгой үсгүүдийг дэс дараагаар нь жагсаавал: а, е, i, 0, 1, ö, ü, na, ba, ха, ya, ja, ya, ta, da, ma, ça, ra, Sa, la, sa, pa-fa, wa. Толийн төгсгөлд «хожим нэмэн зохиосон ба өөр зүйлийн үсгүүдийн аймаг» гэж гарчиглаад, харь хэлний үгс, түүний дотор qa, ka, за, са толгойт үгсийг жагсаажээ.

«Толийн» эцэст зарим тийн ялгалын дагавар, хамаатуулах нөхцөл, асуух сул үг зэргийг жагсааж, ямар үсгээр төгссөн үндсэнд залгахыг тодорхойлжээ.

Монголын толь бичгийн ухааны хуучин сургуультны сүүлчийн том төлөөлөгч Шагж гэлэнд хэдэн зуун жилийн турш тогтсон хуучин уламжлалаас ангижран, шинэ онол, шинэ арга барилыг хүлээн авч, ажил хэрэг болгоно гэдэг хялбар биш байлаа. Шагж гэлэн Хэл зүйн ухааны тухай ойлголттой байсан боловч, үгсийн сангийн судлал, хэл зүйн ухаан хоёрын хооронд зааг гаргаж үздэггүй байсан бололтой. Түүний зохиосон толь бичигт үг, нийлмэл үг, хэвшмэл хэллэг, өвөрмөц хэллэг, холбоо үг, үгийн хэл зүйн хэлбэрийн ялгааг тодорхой гаргаагүй цөмийг толгой үг болгон бичсэн байна.

Толгой үсгийг мөрийн эхэнд тэтгэн бичиж давхар бага хаалтаар ялгажээ. *Abuy-a)) eŋige-yin ax-a degüi ner-i+*. *Vasa Öbör Mongyol-un nigen keseg-ün ner-e, dotor хоуар хосiyi*. Энд хоёр биеэ даасан үгийг нэг үгийн хоёр салбар утга болгон бичжээ. *Abay-a nar )) olan abay-a yi+* «Авга» гэсэн үгийн олон тооны хэлбэрийг бие даасан толгой үг болгон бичжээ. *Abayanar )) Obür mongyol-un nigen keseg-un ner-e dotor-a хоуар хосiyi*. Энэхүү үгийг бие даалган толгой үг болгосон нь зүйтэй. *Abay-a egeči)), abay-a egečiner)) abay-a bergen)), ))*, *abay-a berged)), abay-a kürgen ax-a)), abay-a kürgen ax-a nar))*<sup>9</sup> гэх мэтэс тольд орох ёстой гэж үзвэл бие даасан толгой үг болж орохгүй, «*abra*» гэдэг үгийн өгүүлэлд багтах ёстой. Үгийн хэлбэр болох тооны нөхцөлтэй үг нь үгсийн сангийн нэгж биш, хэл зүйн ай болох тул, үгсийн сангийн давхар утгатай болсон цагт л толь бичигт бие даасан толгой үг болно. Жишээлбэл, дээр дурдсан *abavanar* гэдэг үг «олон авгыг» хэлж байгаа биш, «Өвөр Монголын нэг хэсгийн нэр» байна.

Нэр үгийн — н-тэй, — н-гүй хоёр үндсийг хоёуланг толгой үг болгон бичиж, — н-гүй үндэсний нь хойноос мөн тийм үндэс бүрэлдэхүүнд нь орсон холбоо үг хэллэг, — н-тэй үндэсний нь дараа — н-тэй үндэс бүрэлдэхүүнд нь орсон холбоо үг хэллэгийг бие даасан толгой үг болгон оруулжээ. Жишээлбэл, «чих» гэсэн үгийн араас «чих огтолмуй», «чих хулмайсан», «чих булагдахуй» зэргийн найман холбоо үг, толгой үг болгон бичжээ<sup>10</sup>. «Чихэн» гэдгийг «чихийг+» өөрөөр хэлбэл «чихийг чихэн хэмээмүй» гэж тайлбарлажээ. Түүний хойноос «чихэн гэр», «чихний язгуур», «чихний ёроол», «чихний ухуур», «чихний омог», «чихний унжлага», «чихний хуудас», «чихний сүв», «чихний шүхэр», «чихний дэлбэ», «чихний хөвөө», «чихний хатгуур»<sup>11</sup> гэх мэтсийг толгой үг болгон бичиж, тус тусын тайлбарыг хийжээ.

Монгол хэлний тайлбар тольд нэг үгийн —н-тэй, — н-гүй хоёр үндсийг бие даасан хоёр толгой үг болгон оруулах шинжлэх ухааны үндэслэл байхгүй, «чих» гэдэг үгийг тийн ялгалаар ялгаллаад үзье.

1. Нэрлэх: чих

2. Харьяалах: чихний

3. Өгөх орших: чихэнд

4. Заах: чихийг

5. Гаргах: чихнээс

6. Үйлдэх: чихээр

7. Хамтрах: чихтэй

Нэрлэх, заах, үйлдэх, хамтрахын тийн ялгалд «чих» гэсэн — н-гүй үндэс, харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгалд «чихэн» гэсэн —н тэй үндэс хэрэглэгдэж байна. Энд «чих», «чихэн» гэсэн хоёр бие даасан үг байна гэж үзэж болно гэж үү?<sup>12</sup> Нөгөө талаар угтаа нэг үгийн салбар утга боловч, эдүүгээ хэл зүйн талаар өөр өөрөөр хэлбэржин, үгсийн сангийн бие даасан өөр өөр нэгж болж байгаа тохиодолд тэдгээрийг тус бүрт нь толгой үг болгон бичих нь зүйтэй<sup>13</sup>. Жишээлбэл: **Сар** жилийг арван хоёр хуваасны нэгтэй тэнцэх цаг хугацааны нэгж: тийн ялгалын хэлбэр нь: сарын, сард, сарыг, сараас, сараар, сартай; **Сар (ан)** дэлхийн дагуул, нарны гэрэлд гэрэлтэн харагдах тэнгэрийн эрхэс; тийн ялгалын хэлбэр нь сар (ан), сарны, саранд, сар (н) -ыг, сар наас, сарнаар, сар (ан) тай; од (он) тэнгэрийн эрхэс; тийн ялгалын хэлбэр нь одны, одонд, одыг, одноос, одоор, одтой; **Одон (г)** гавьяа байгуулагсдад шагнах тэмдэг; тийн ялгалын хэлбэр нь: одонгийн одонд одонг, одонгоос, одонгоор, одонтой.

«Чулуун» гэсэн үг бүрэлдэхүүнд нь орсон «чулуун нүүрс», «чулуун давс мэтийн холбоо үгс уг тольд арван дөрөв байхад «чулуу гэсэн үггүй үндэс нь байхгүй байна, «Цагаан» гэсэн үг бүрэлдэхүүнд нь орсон толгой үг 54 байна.

Үйл үгийг «Чандманийн эрхэд гол төлөв толийн уламжлалт хэлбэрээр, өөрөөр хэлбэл одоо цагийн —müi, —müi гэсэн нөхцөлтэй хэл бэрээр оруулсан байна. Тэгэхдээ үйл үгийн хэрэглэгдэх байдлыг хар галзсан бололтой. «Авлах» гэдэг үгийг abalamui abalayulmüi, abalar-a iremüi, abalar-a odunui, abalalčamui, abalaedumui гэсэн толгой үгээр «авах гэдэг үйл үгийг abur-a odumui, abuyulumui, abaloldumui, abumui, abučaldumui, abur-a obuylumui, abur-a od, abuldumui, abučaldumui, abulkaylumui, adulčan köldebe гэсэн толгой үсгээр тус тус оруулсан байх жишээтэй. Мөн тэрчлэн хоёрдугаар биеийг шууд захирах хэлбэр, ирээдүй цагийн —n -а, -n-е нөхцөлтэй хэлбэр, —ba, —be нөхцөлтэй өнгөрсөн цагийн хэлбэр, -basu, -besu нөхцөлтэй болзох хэлбэр, зэргийг бие даасан толгой үг болгон бичсэн цөөнгүй тохиолдоно. Жишээлбэл: есі, есін-е, есibe, ab, asx-а, abasu, abaci, bögesü<sup>15</sup> гэх мэт. Bögesü гэдгийг «биеэс төрж зуух хорхойн нэр, хэвэл их, зургаан хөл буй. Бас bolbasu хэмээх үг eyimü bögesü, teyimü bögesü хэмээхүйн зэрэгт хэрэглэмүй» гэж тайлбарлажээ. Ингэж ил бодтой хоёр өөр үг, үйл үг нэр үг хоёр байсаар атал нэг толгой үг болгосон нь арвин тохиолдож байгаа бөгөөд энэ нь бичлэгийг онцгой анхаарах зарчмыг баримталсны харгаа буй за. «ууян») үгний аялгуу, ав хугаан, ах юугаан хэмээх зэрэг эр үсэг орсон үгний сүүлд бичмүй» «yügen утга юу гаан хэмээхүйн адил, эх юүгээн, дүү юүгээн хэмээх зэрэг эм үсэг орсон үгний сүүлд бичмүй. Энэ бээр юү толгойгоор унших үг боловч урт шилбэ үгүй бичигдэх учир энд оруулбай»<sup>16</sup> гэж зохиогчийн бичсэн нь миний санааг нутлаж байна.

Монгол хэлний үйл үгийн хоёрдугаар биед шууд захирах нөхцөл нь тэн хэлбэрээр илэрдэг гэдэг нь эдүүгээ хэл зүйн анхны мэдэгдэхүүнтэй хүн бүрд мэдээжийн хэрэг билээ. Гэтэл хорьдугаар зууны эхэн үеийн Монголд байдал тийм байсангүй. Ялангуяа хуучин сургуультаан эрдэм тэд уламжлалаа сахин, «Бос») ...хэвтсэн сууснаа халж дээш бол хэ - мээхүйд+. «ав») өгсөн юмыг хураатугай хэмээн шаардах үг»<sup>17</sup> гэх мэтийн толгой үгийг тольд оруулан тайлбарласаар байлаа.

Төлөөний үгийн зүйл, тухайлбал, биеийн төлөөний үгэнд үгсийн сангийн утгын үүднээс зөв тайлбар хийснийг тэмдэглэлтэй байна. „ĉi)) хэлэлцэхүйд хүний биеийг заан өгүүлэх үг<sup>18</sup>. ĉinu)) хэлэлцэхүйд хүний бие ба юмыг чиний бие ба юм хэмээмүй<sup>19</sup>. ĉimasa)) чиний биеэс хэмээх үг, бас ĉimasa хэмээмүй. ĉimadur)) чиний биед хэмээх үг, ĉimayi)) чиний биеийг хэмээх үг ĉimaluу-а чиний бие лүгээ хэмээх үг»<sup>20</sup> гэж мэт.

Монгол хэлээр өгүүлэгчдэд нэгэн үг мэт сэтгэгдэх болсон нийлмэл үгийг толгой үг болгон үргэлж бичсэн байна. Жишээлбэл: Abaĉi юмыг авч од хэмээхүйд + Abaĉimui)) юмыг авч одохуйг + <sup>21</sup> «Аваачих» гэдэг үг «аваад очих» гэсэн холбоо үг урт удаан хугацаанд өргөн хэрэглэгдсэний үр дүнд нийлмэл үг болсон нь буй за.

Шагж гэлэнгийн «Чандманийн эрхэд» үгийн утгыг ерөнхийдөө зөв гаргаж, товч тодорхой илтгэсэн байна.

«Abayai) ) биеийн ахыг + Бас хүнийг хүндэлж дуудах үг. Бас урьдын цагт хааны өргөмжлөөгүй хүргүүнийг - Abayai гэдэг үг орчин цагийн утга зохиолын хэлэн Abuyai гэдэгтэй дуудлага ижил болж, нэгд настай эхнэр хүнийг нэрлэх, хоёрт, гуай гэсэн, гуравт, гэргий гэсэн утгатай болжээ<sup>22</sup>.

«büm тооны орны нэр, арван түмийг нэг + түвд үг, бас бөөмнөлдсөн юмыг ийм юм хэмээмүй». Уйгуржин бичигт бичлэг нэг боловч дуудлага, өөр, тооны нэр нь büm bum гэсэн дуудлагатай, хоёр тохь нь böm гэсэн дуудлагатай билээ. Нэгдүгээр үгийн гарлыг бас заажээ. Үнэхээр түвдээр «'bum» гэдэг.

gusi)) бичиг төсөөлөх хүнийг + эдүүгээ бичиг орчуулахад мэргэн хүнийг +»...Маш зөв тайлбарлажээ. Гагцхүү орчин үеийн монгол хэлэнд нэгдүгээр утга нь нэгэнт алга болсон учир түүнийг «хуучирсан» гэсэн тайлбартайгаар хоёр тохь утга болгон бичих буюу «Чандманий эрх» мэтийн асар том тольд бүр орхичихсон ч болох билээ. Өмнө өгүүлсэн büm bum гэдэг үгийн гарлын тухай дурдсан атлаа güsi гэдэг үгийн гарлын тухай тэмдэглэсэнгүй. Gүsi гэдэг бол хятад хэлний gosi «улсын багш» гэсэн үгнээс гаралтай аж.

«Laksan)) Бурханы биед ахуй сайн бэлгийг +. Эдүүгээ эрхэм хүний биеийг хүндэлж +». «Лагшин гэдэг үг санскрит хэлний laksana «бэлэг, тэмдэг, Бурханы гучин хоёр бэлэг тэмдгийн нэг» гэсэн утгатай үг байна.

«Sүni)) үдшээс гэгээрэхүйд хүртэлх цагийг + «Шөнө» гэдэг үгийг үүнээс илүү тодорхой бөгөөд товч тайлбарлах боломж байх болов уу даа!?

«Suyidkel)) тогтож хэрэглэх тоог +. Төдий л ойлгомжтой бус тайлбар. Орчин үеийн монгол хэлэнд «сүйтгэл» гэдэг үг: 1) үрлэг, үрэгдэл, зарлага, зардал, («сүйтгэл гаргах», «сүйтгэл ихтэй»); 2) өр, төлбөр, төлөөс («дайны сүйтгэл») гэсэн утгатай байна.

«Sүkegemüi)) хүний үзлийг буруушаахуйн зэргийг + «Орчин цагийн Монгол утга зохиолын хэлэнд ийм үйл үг байхгүй. Харин 1. «овсгоо, ов заль»; 2) «сүлбэр, холбоо» гэсэн хоёр утгатай «сүүхээ» гэдэг нэр үг буй HE түүнтэй язгуур нэгтэй байж болох юм. Эртний турк хэлэнд «загнах, буруушаах» гэсэн утгатай «sök-»<sup>23</sup> гэсэн үйл үг байснаас гадна орчин үеийн турк хэлнүүдэд тухайлбал, киргис хэлэнд сөк-»<sup>24</sup>, узбект «сук— загнах<sup>25</sup>, хасагт «сөг-» 1) загнах; 2) шүүмжлэх<sup>26</sup>, азербайжанд «сөг-> — «загнах»; буруушаах<sup>27</sup> гэсэн үг байна. Сүүлийн жишээнд эгшиг нь

урт байгаа нь орчин цагийн монгол хэлний «сүүхээ» гэдэг үгийн язгуурын урт эгшиг эртний сурвалжтайн гэрч мөн.

«gabur») янз давсанд адил, үнэр анхилам их, эмд хэрэглэмүй<sup>28</sup> Оновчтой тайлбар. Бусад хэлний тайлбар тольд «гавар» гэдэг үгийн тайлбар иймэрхүү л байдаг. Орчин үеийн тольд «эмээс» гадна «техникт» хэрэглэнэ гэж нэмсэн байдаг. Араб хэлний үг kafur.

Хаяан-ну bičigsen manju mongyol ügen-nü toli -ийн нөлөө үгийн бичлэгт хүртэл үзэгдэж байна. Жишээлбэл, yood yud гэхийг yongsin yungsin гэхийг гэж эр үгэнд үсэг бичсэн байна.

«Чандманийн эрх» тольд жирийн тайлбар тольд биш, нэвтэрхий тольд байвал зохих лавлах хэрэглэгдэхүүн бас нилээд орсон байна. Жишээлээд Хүнзийн суртлын «Ачлалт ном», бурхны шашныг шинэчлэгч Зонваагийн нэр зэргийг дурдаж болох байна.

Зохиогч Шагж нь гэлэн хүн байсан учир түүний үзэл санаа зарим үгийн тайлбарт тусчээ. Жишээлбэл: sakyamuni)) Jambutyib-un oron-a eldeb mayu üjel surtal delgerčü, xarilčan kimuraldun delekei dakin-u kü mün amitad čaylači ügei jüdegüri-yi amsan бүкүй nigen čay-tur Eneđkeg ün oron-u Ariyun ldegetu kemengdekü nigen Siduryu dölgen хаяан-у ахамад күбегүн болун mendülejü, tedü erdem soyol-un tuyil-dur күрүгед, naran-u gerel-ber odod-un sur-i daruxu metu хамай mavu üjel-i ariyun siduryu jüi jok s-iyar сүкегжү, ceber ičimtegei sašin surtal delgerегүлүн, delekej dakin-u jobalang-un egüde-yi хаважу, jiryalang-un egüdene хандууиум jokiyaysan tengsel ügei yeki ачиту Burхан-у алдар, Tenggeri)) yurban sayin jayayan-u nigedüger-i +

Феодалын нийгэмд өсч хүмүүжсэн, энэ билэг төгөлдөр эрдэмтэн шинэ зарчмыг баримтлан тайлбар толь зохиож, шинэ юм бүхнийг хүлээн авах хүсэлтэй байсан авч лам хүний явцуу үзэл хувьсгал мандсан нийгэмд шинэ тутам үүсэн гарч байгаа үзэгдлүүдийг түргэн ойлгож тусган авахад саад болж байсан бололтой. Жишээлбэл, 1929 онд зохиож дуус гасан энэхүү тольд «хувьсгал» гэдэг үгийг “цэргийн байдал тогтуур үгүй гэнэт ийм, гэнэт тийм болохуйн зэргийг нь (хувьсгал хэмээмүй) » гэж тайлбарлажээ. Шигмэнэ, Зонхваа, Хүнзийн нэр толгой үг болон орон атал Сүхбаатарын нэр байхгүй байна. Гэвч бид өнөөдөр Монголын толь бичгийн ухааны хуучин сургуультаан тэр авьяастай, хөдөлмөрч том эрдэмтнийг хуучин хүлээснээс бүрэн ангижирч чадаагүй гэж шүүмжлэх амархан. Хувьсгал дөнгөж мандаад, шинэ юм соёолж байсан цагт уйгуржин монгол бичгийн цагаан толгойн үсгийн дэс дараа дээр үндэслэсэн Монгол хэлний тайлбар толь зохионо гэдэг Монголын толь бичгийн ухаанд хувьсгал хийнэ гэсэн үг байлаа. Энэ эрдэмтэн эрдэм шинжилгээний ажилдаа жинхэнэ хувьсгалч хүн байлаа.

Шагжийн «Эрхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманийн эрх» нь Монгол толь бичгийн ухаанд шинэ үеийг нээсэн чухал бүтээл юм. Тэрхүү бүтээл хэдүйгээр хэвлэгдэн, нийтийн хүртээл болоогүй боловч, бичмэлээр Улсын нийтийн номын санд хадга-

1 Шагж, Эрхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманийн эрх, I, II, II, IV, бичмэл, Улаанбаатарын Улсын нийтийн номын сангийн бичмэл номын хөмрөгт хадгалагдан буй.

2 Шагж, дүрдсан зохиол, 1 а

лагдан, хувьсгалын үед зохиосон бусад толь бичгүүдэд нөлөө үзүүлсэн билээ.

<sup>3</sup> Хауан-nu bičigsen manju mongyol ugen-nu toli bičig, Энх-Амгалангийн тавин зургадугаар (1717) он, бар, Бээжин. оршил

<sup>4</sup> Дурдсан зохиол

<sup>5</sup> Хауан-nu bičigsen manju mongyol ügen-nü toli bičig, Тэнгэрийн тэтгэсний наймдугаар (1746) он, бар, Бээжин.

<sup>6</sup> **Шагж**, дурдсан зохиол, 722 а,

<sup>7</sup> Хауан-nu bičigsen manju mongyol ügen-nü toli bičig, Цаг улиралын зүйл, тавдугаар

<sup>8</sup> **Шагж**, дурдсан зохиол, 1 в

<sup>9</sup> **Шагж**, дурдсан зохиол, 2 а

<sup>10</sup> **Шагж**, дурдсан зохиол, 683 а

<sup>11</sup> **Шагж**, дурдсан зохиол, 684 в

<sup>12</sup> **А. Лувсандэндэв**. Хэл бичгийн ухааны зарим асуудал, 1, УБ. 1982. 107—109

<sup>13</sup> **А. Лувсандэндэв**, дурдсан зохиол, 131-р тал

<sup>14</sup> **Шагж**, дурдсан зохиол, 2 в

<sup>15</sup> **Шагж**, дурдсан зохиол, 576, 286, 2 а, 2 в, 266 а,

<sup>16</sup> **Шагж**, дурдсан зохиол, 107 в

<sup>17</sup> **Шагж**, дурдсан зохиол, 266 в

<sup>18</sup> **Шагж**, дурдсан зохиол, 681 а

<sup>19</sup> **Шагж**, дурдсан зохиол, 681 в

<sup>20</sup> **Шагж**, дурдсан зохиол, 687 а

<sup>21</sup> **Шагж**, дурдсан зохиол, 2 в

<sup>22</sup> **Я. Цэвэл**, Монгол хэлний товч тайлбар толь, УБ. 1966. 15-р тал

<sup>23</sup> Древнетюркский словарь Л., 1969, с. 510

<sup>24</sup> **К. К. Юдахин**, Киргизско-русский словарь, М., 1965, 659

<sup>25</sup> Русско-узбекский словарь, под редакцией Р. Абдурахманова, М., 1954, с. 748

<sup>26</sup> **Б. Базылхаан**, Казах-монгол толь УБ., 1977, 222-р тал.

<sup>27</sup> **Э. В. Севортян**, Африксы глаголообразования в азербайджанском языке, М., 1962,

с. 312

<sup>28</sup> **Шагж**, дурдсан зохиол, 809 в

## ГУРВАН МАНДАЛЫН ТҮРЭГ БИЧЭЭС

Л. БОЛД

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн

Р. БЯМБА

БНМАУ-ын нутагт буй хад чулуунаа сийлж үлдээсэн бичиг үсгийн дурсгалууд бол өнөөгийн бидэнд уламжлагдан ирсэн эдийн болон оюуны соёлын зүйлсийн адил Төв Азийн нүүдэлч түмний соёл, түүхийг судлах үнэт хэрэглэгдэхүүн юм. Үүнийг манай ард түмэн сайтар ухамсарлан, хайрлан хамгаалах талаар үлэмж анхаарч ирсний нэг тодорхой баримт бол түүхийн чухал мэдээт газар орныг «**Бичигт хад**», «**Бичигт хошуу**» гэх мэтээр эрхэмлэн нэрлэж хойч үеийнхэндээ заан уламжлуулан ирсэн явдал юм. Иймээс бичиг дурсгалыг анх нээгчид нь